



БУЛГАН АЙМАГ
САЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

- 2015 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А116

Их хүрэмт

Иргэний танхимын ажиллах үйл ажиллагааны
журам батлах тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын 2009 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 20 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний оролцоог нэмэгдүүлэх санал хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор байгуулсан "Иргэний танхим"-ын үйл ажиллагааны журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтэнд хяналт тавих, удирдан зохион байгуулах ажлыг Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн\Н.Юмчинрагчаа\, ашиглалт үйлчилгээний ажлын ажилтан \Д.Мөнхзул\, \Р.Дуламжав\ нарт даалгасугай.

ДАРГА



С.ЛУВСАНЦООДОЛ